



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
- 2.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт даалгасугай.
- 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөрийн бодлогын газар, Гэр бүлийн бодлогын газарт тус тус үүрэг болгосугай.
- 4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн А/135 дугаар тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн А/124 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Л.ЭНХ-АМГАЛАН

ХОХИРОГЧИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТАД ХАМРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журам нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасны дагуу хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэхдээ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

1.3.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч /цаашид "хохирогч" гэх/ нь энэхүү журамд заасан үйлчилгээнд хамрагдана.

1.4.Эрх бүхий байгууллагаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн амь нас, эрүүл мэндэд бодитой аюул, заналхийлэл бий болсныг тогтоож Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасны дагуу оршин суугаа газраас нь нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд хохирогчийн хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах, эсхүл ажлын байраар хангахад энэ журам мөн адил хамаарна.

Хоёр.Хохирогчид үйлчилгээ үзүүлэх

2.1.Хохирогчийн гаргасан хүсэлтийн дагуу дараах үйлчилгээг үзүүлнэ:

- 2.1.1.хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамруулах;
- 2.1.2.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамруулах;
- 2.1.3.мэргэжлийн анхан шатны ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах;
- 2.1.4.мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтад хамруулах;
- 2.1.5.ажлын байранд холбон зуучлах.

2.2.Үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллага хохирогчийн хүсэлтийг үндэслэн мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалтад хамруулж болно.

2.3.Энэ журмын 2.1-д заасан үйлчилгээнд хамрагдах хүсэлтийг хохирогч өөрөө, эсхүл энэхүү журмын 2.4-т заасан байгууллагаар уламжлан аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана.

2.4.Хохирогч энэхүү журмын 2.3-т заасны дагуу хүсэлтээ дараах байгууллагаар дамжуулж болно.

- 2.4.1.хохирогчид үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага;
- 2.4.2.цагдаа болон тагнуулын байгууллагын хяналтад байгаа бол тухайн байгууллага.

2.5.Аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага нь хүсэлт гаргасан хохирогчид хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ хийж, тухайн иргэний ур чадвар, онцлог хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/, холбогдох сургалтад хамруулах, ажилд зуучлах үйлчилгээг зохион байгуулна.

2.6.Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүсэлт гаргасан хохирогчийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3-т заасан үйлчилгээнд хамруулах эсэх шийдвэрийг энэ журмын 2.5-д заасан ур чадварын үнэлгээнд үндэслэн шийдвэрлэнэ.

2.7.Хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээнд үндэслэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах шийдвэрийн талаар хохирогчид заавал танилцуулсан байна.

2.8.Хүсэлт гаргасан хохирогчийг энэ журмын 2.1.1-2.1.5-д заасан үйлчилгээнд хамруулах ажлыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нэн даруй эхлүүлж, холбогдох харьяа байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

2.9.Аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага нь зохих мэргэжил, боловсрол эзэмшсэн хохирогчийг ажлын байранд зуучлах арга хэмжээ авна.

2.10.Хохирогчийг ажлын байраар хангаж чадаагүй тохиолдолд түүнийг харьяа аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага ажил хайгчаар бүртгэнэ.

2.11.Журмын 2.1-д заасан үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

2.12.Журмын 2.1-д заасан үйлчилгээ үзүүлэх явцад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон талаарх бүхий л мэдээллийг нууцална.

Гурав.Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллагын чиг үүрэг

3.1.Энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус байгууллага болон олон улсын байгууллага тусламж, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үйл ажиллагааг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хэрэгжүүлэх байдлаар төрийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

3.2.Төрийн байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ, туслалцаа үзүүлэх чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж болно.

3.3.Үйлчилгээ үзүүлэгч төрийн бус байгууллага хохирогчийг ажлын байраар хангах, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулахдаа дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.1.Журмын 2.1-т заасан үйлчилгээг хэрэгжүүлэх зорилгоор сургалтын зохих бүртгэлтэй мэргэжлийн сургалтын байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж болно;

3.3.2.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн баримжаа олгох сургалтад хамруулахдаа хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад холбон зуучлах;

3.3.3.Ажил үүргийн дагуу туслалцаа, үйлчилгээ үзүүлж байсан хүн, хуулийн этгээд хохирогчийн мэдээллийг задруулахыг хориглоно;

3.3.4.Хохирогчид энэ журамд заасан үйлчилгээ үзүүлэх явцад өөр хүн хохирогч болсон, эсхүл хохирогч болох эрсдлийн талаар сэжиг, таамаг илэрсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага энэ талаар цагдаагийн байгууллагад шуурхай мэдээлнэ.

Дөрөв.Санхүүжилт

4.1.Журмын хэрэгжилтийг зохион байгуулах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

4.1.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө;

4.1.2.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө;

4.1.3.Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хуваарилсан хөрөнгө;

4.1.4.Хандив, тусламж;

4.1.5.Бусад.

Тав.Үйл ажиллагааны тайлагналт, хяналт

5.1.Аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллага, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт нь журмын хэрэгжилтийн сарын тайлан мэдээг Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хагас, бүтэн жилээр хүргүүлнэ.

5.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 5.1-т заасан тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийж, хагас, бүтэн жилээр Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албанд тус тус хүргүүлнэ.

5.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба тайланг хүлээн авч, үйлчилгээ үзүүлсэн хохирогчийн тухай мэдээллийг ажлын 5 хоногийн дотор хүн худалдаалах гэмт хэргийн мэдээллийн санд оруулна.

5.4.Журмын хэрэгжилтэд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл хяналт тавих, тайлан мэдээг сонсох бөгөөд шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийнэ.

Зургаа.Бусад

6.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

--- оОо ---